

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙ АЛБАН ХААГЧ НАРААС АВСАН СУДАЛГАА

2012 он


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагчдын 35 хувь нь эмэгтэй албан хаагч байна. Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдын дунд явуулсан санал асуулгаас үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй албан хаагчдын ихэнх хувь буюу 67 хувь нь шууд ялтан, хоригдолтой харьцаж ажилладаг байна.

Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй албан хаагчдын аюулгүй байдлыг хангах талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дотоод дүрэм, журам, зааварт тусгайлан тусгасан байдаг. Эмэгтэй албан хаагчид ялтан, хоригдогчтой ажиллах үед ялтан, хоригдогчийн зүгээс хэл амаар доромжлох, биед халдах асуудлууд гардаг талаар энэхүү санал асуулгад тусгажээ. Иймд албан хаагчдын аюулгүй байдлыг хангах нь нэн түрүүнд онцлон хөндөх чухал асуудал болж байгааг анхаарах хэрэгтэй.

Эрүүл мэндийн тухайд: Санал асуулгаас үзэхэд албан хаагчид албан үүргээ гүйцэтгэж байхдаа бэртэж гэмтсэн, халдварт өвчин авсан тухайгаа удирдлагад мэдэгддэггүй байна. Энэ талаар эмэгтэй албан хаагчдын 80 хувь нь удирдлагад мэдэгддэггүй гэж хариулсан байна. Учир нь албан хаагчид ажил үүргээ биелүүлж байх үед бэртэж гэмтдэг, халдварт өвчин тусдаг хэдий ч удирдлагын зүгээс зэмлэл хүртэх зэрэг асуудлуудаас болж нуун дарагдуулдаг байна. Мөн бусад албан хаагчдад халдварт өвчин тараах, эсвэл авсан бэртэл гэмтэл нь хүндэрч улмаар албан хаагчийн эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох сөрөг талтай юм.

Албан хаагчдаас ажлаа хийж байхдаа яг ямар төлийн бэртэл гэмтэл, өвчин авсан талаар санал асуулгаас үзэхэд:

- Сүрьеэ өвчин;
- Эрэгтэй албан хаагчийн адил норматив хийлгэдэг учраас нуруундаа бэртэл авсан;



Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

- Лабораторын химийн бодист хордсон үүнээс үүдээд элэг муудсан;
- Албаны автомашины осолд орсон;
- Хөлөө гэмтээж байсан. Уушиг устсан;
- Амьсгалын замын халдварт өвчин туссан;
- Байнгын стресст ордог үүнээс болоод бамбай булчирхай болон зүрхний өвчтэй болж байна;
- Хээрийн сургалтын үед хөлөө хугалж байсан;
- Мэдрэлийн өвчин, нүүрний саажилтын өвчин тусаж эмчлүүлсэн ч үлдэц үлдсэн;
- Ажлын тэмцээнд орж байгаад долоовор хуруугаа мулталж байсан;
- Хоригдогчийн амьдрах байранд байрлаж ажилласнаар тамхины утаанд хордох, нүүрээр юм гарах, толгой байнга өвдөх болсон зэрэг хариуг өгсөн байна.

Иймд удирдлагын зүгээс албан хаагчдын эрүүл мэндэд анхаарал хандуулж, тэднийг эмчийн үзлэгт хамруулж, халдварт өвчин тусах, бэртэл гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, өвчин туссан, гэмтэж бэртсэн тохиолдолд удирдлагад зайлшгүй мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн тухайд: Тус байгууллагын эмэгтэй албан хаагчдаас авсан санал асуулгыг үзэхэд 82 хувь нь илүү цагаар ажилладаг бөгөөд илүү цагаар буюу 7 хоногийн амралтын өдөр ажиллаад нөхөж амраагүй үедээ 1.5 буюу түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс авч чадаагүй гэж 96 хувь нь хариулсан байна. Харин Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын тушаалаар баталсан “Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын хөдөлмөрийн дотоод журамд” заасны дагуу долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл, ердийн өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна, ажлын цаг өглөө 09.00 цагт эхэлж, 13.00-14.00 цагийн хооронд завсарлаж, орой 18 цагт дуусна⁴⁴ түүнчлэн байгууллагын захиргааны санаачилгаар илүү цагаар болон амралтын өдөр ажиллуулсан албан хаагчдыг нөхөн амруулахгүй бол түүнд 1.5 дахин буюу түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгохоор заасан байдаг.

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа


Иймээс ажлын шаардлагаар албан хаагчдыг илүү цагаар ажиллуулсан бол Хөдөлмөрийн хууль тогтоомж болон тус газрын дотоод журмыг хэрэгжүүлэх чиглэлээр анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй байна.

Биед халдсан байдал, хэл амаар доромжлох асуудал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зарим удирдах албан тушаалтан ажилтан албан хаагчидтайгаа харьцах харилцаа, ёс зүйн тал дээр анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна. Мөн ялтан, хоригдол нар ажилтан, албан хаагчидтай хүндэтгэлтэй харьцах харьцааны асуудлыг авч үзэх шаардлага гараад байна. Учир нь эмэгтэй албан хаагчдыг удирдлагын зүгээс биед халдах, хэл амаар доромжлох асуудал байсаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй албан хаагчдаас авсан санал асуулгаас удирдах албан тушаалтан нь биед халдах талаар асуухад 1 хувь нь байнга халддаг, 6 хувь нь хааяа халддаг бөгөөд удирдлагын зүгээс хэл амаар доромжилдог эсэх талаар 6 хувь нь байнга, 27 хувь нь хааяа гэж хариулсан байна. Харин ялтан, хоригдлуудын зүгээс хэл амаар доромжилдог эсэх гэсэн асуултад 13 хувь нь байнга, 16 хувь нь хааяа гэсэн байна, биед халддаг эсэх асуулгад 7 хувь нь хааяа гэж хариулсан байна.

Ялгаварлан гадуурхалт: Судалгаанаас үзвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын дунд нас, хүйсээр ялгаварлан гадуурхах явдал гарсаар байгаа бөгөөд эрэгтэй албан хаагчдад давуу боломж олгодог, нас, хүйс харгалзаж албан тушаал дэвшүүлдэг эсэх талаар асуултад нийт санал асуулгад 38 оролцогчдын 63 хувь нь ийм асуудал байгааг хүлээн зөвшөөрсөн хариултуудыг өгсөн байна.

Мэргэжлийн болон бусад сургалтад хамруулахад мөн адил хүйс харгалзах, эрэгтэй албан хаагчдад давуу боломж олгох тохиолдол байдаг байна. Санал асуулгад хамрагдсан албан хаагчид доорх асуудлуудаар ихэвчлэн ялгаварлан гадуурхдаг гэж:

- цол нэмэх асуудал дээр удирдах албан тушаалтан зүс царай, бие зэргийг хардаг, танил талтай хүн л цол нэмдэг;
- залуу албан хаагчдыг илүү харж үздэг;
- танил тал харж дэвшүүлдэг;
- эрэгтэй албан хаагч илүү байна гэж дандаа дарамталдаг;



Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа


- цол нэмэх нь эмэгтэй хүнд хэцүү;
- ихэнхдээ дарга нарын эхнэр тушаал дэвшиж цол авдаг;
- танил талтай албан хаагчид илүү эрх эдэлдэг;
- дээд шатны албан тушаалтнуудад л байр олгодог;
- олон жил ажилласан хүмүүст байр олгох магадлал өндөр залуу шинэ ажиллагчдад байр олгох магадлал маш бага;
- сургалт, семинарт хүйс заадаг, байр орон сууцтай болоход ажилласан жил хардаг зэрэг хариулт өгсөн байна.

Ажлын байран дахь бэлгийн дарамт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын дунд ажлын байран дахь бэлгийн дарамт байгаа талаар Комиссоос авсан санал асуулгаас харж болох юм. Энэхүү санал асуулгад эрэгтэй албан хаагчдын зүгээс бэлгийн харьцаатай холбоотой эвгүй, ичээх үг хэлэх, бэлгийн сэдэлтэй санал хүсэлт тавих, уриалах, тулгах, ширтэх, шалиг нүдээр харах, дохио зангаа үзүүлэх, өдсөн зураг хэвлэмэл хуудас, дүрс үзүүлэх, мессеж бичих, хүзүү хоолой, хөх өгзгийг шүргэх, илэх гэх мэтээр биед хүрдэг зэрэг зөрчлүүд гардаг байна.

Үүний зэрэгцээ хүчирхийлэхийг завдах, хүчирхийлэх, бэлгийн харьцаанд орох тохиолдол гардаг талаар энэхүү санал асуулгад тусгажээ. Мөн зарим эмэгтэй албан хаагчид цэргийн цол нэмэхэд бэлгийн дарамтад орж байж цол нэмдэг талаар дурдсан байна.

Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хүн сэтгэл санааны дарамтад орж сэтгэл тавгүйрэх, ажиллах урам зориг, итгэл үнэмшлээ алдах, гэр бүл салалт, хүсээгүй жирэмслэлт, ажил таслах, бүтээлч чадвар алдагдах, ажлын бүтээмж буурах, ажлын дадлага туршлагаа алдах, ажлаа орхихоос өөр аргагүй байдалд хүрэх, улмаар ажлаас гарах шийдвэр гаргах зэрэг сөрөг үр дагаврыг дагуулдаг.

Иймд дээрх зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авч, цаашид ажлын байран дахь бэлгийн дарамтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажиллах, шаардлагатай байна.



Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

Хавсралт

№	Асуулт					
1	Таны нас	А	Б	В	Г	
		20-30 /32	30-40/34	40-50/21	50дээш 13	
2	Ам бүл	1-4	4-6	6-8		
		77	23	2		
3	Таны боловсролын түвшин	Дээд	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Тусгай дунд	Бөглөөгүй
		67	8	11	14	3
4	Та ажил үүргийнхээ улмаас өөр аймаг хотоос шилжин сууршисан уу ?	А тийм	Б үгүй	Тийм бол ямар аймаг хотоос шилжин ирсэн бэ ?		
		23	78	Улаанбаатар хот – 1 Хэнтий – 2 Баянхонгор – 2 Увс – 1 Дорноговь – 1 Завхан -1 Өвөрхангай – 3 Сэлэнгэ – 3 Төв аймаг – 5 Говь-алтай – 1 Дархан – 2 Дорнод – 1		
5	Таны эрхэлдэг ажил албан тушаал	Холбоочин – 9 Сувилагч – 11 Хянагч – 18 Эмч – 14 Эдийн засагч – 1 Нийгмийн ажилтан – 3 Оператор – 3 Нярав – 4 Ахлагч – 1 Хөдөлмөрийн даамал – 1 Бичиг хэрэг – 3 Хүний нөөц сургалт хэвлэл мэдээлэл олон нийт хариуцсан даргийн туслах – 2 409-р ангийн даргийн туслах – 1				

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

		Дэд дарга – 1 Ня-бо – 3 Эд хариуцагч – 1 сэтгэл зүйч - 3 харуул хамгаалтийн ажилтан – 2 асрагч – 4 тоо бүртгэгч – 8 нийгмийн ажилтан – 7				
6	Та шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хэд дэх жилдээ ажиллаж байна вэ?	1-5	5-10	10-15	15-20	30 дээш
		43	19	17	15	2
7	Та ямар гэрээний үндсэн дээр ажил хөдөлмөр эрхэлдэг вэ?	А Хөдөлмөрийн гэрээ	Б Үр дүнгийн гэрээ	В Гэрээ байгуулаагүй	Г Төрийн албан хаагч	Д Мэдэхгүй
		2			97	3
8	Та ажлын байрны тодорхойлолт цалин хөлс нэмэгдэл , урамшуулал ажил амралтын цагынхаа талаар тодорхой мэдээлэлтэй эсвэл ийм мэдээлэл авах боломжоор хангагдсан уу?	А Тийм	Б Үгүй	Бөглөөгүй		
		83	18	1		
9	Та сүүлийн 3-н жил мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан уу ?	А Тийм	Б Үгүй	Тийм бол тодорхой бичнэ үү ?		
				- ШШГЕГ НА – 9хоногийн сургалт - Харуул хамгаалттын чиглэлээр - ШШГЕГ-н офицерийн сургалт 14 хоног - ШШГЕГ-н сургалтын албаны сургалт – хоног 7 - Халдварын резидент - ЭМШУС-н генетик удам зүйн мэргэжил 1 жил - Орхон их сургуулийн хууль зүйн сургууль		

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

									<ul style="list-style-type: none"> - хуулийн анги - ЭМШУС 3жил магистер, 2жил - ОХУ Эрхүү муж мэргэжил дээшлүүлсэн. - Кридет цагийн эмчийн сургалтууд, - Удирдлагийн академ хүний нөөцөөр 1 жил, - ШШГЕГ-н нийгмийн ажилтаны сургалтанд долоо хоног, - Нийгмийн ажилтны сургалт 14 хоног- 2хүн, - Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хамруулсан сургалт, - ШШГЕГ-н холбооны сургалт 3 хоног – 5хүн - Улаан – үүд хотод 10 хоногийн сургалт - ШШГЕГ-н ня-бо эдийн засагч нарын мэргэжил дээшлүүлэх сургалт - Цагдаагийн акамед ичнээ анги – 2хүн - ЭМШУС сувилахуй 3сарын курс - Боловсон хүчний сургалт - Хөрөнгийн бирж үнэт цаасны 14 хоногийн сургалт - Сутай дээд сургалт оройн анги 2.5жил
		46	54						
10	Та өдөрт хэдэн цаг ажилдаг вэ?	A \4 хүртэлх\	Б \4-6\	В \6-8\	Г. \8-10\	Д \10-12\	Е \12 дээш \	Бөглөөгүй	
				18	47	1	20	16	
11	Та илүү цагаар ажилладаг уу ?	A \тийм\	Б \үгүй\	Бөглөөгүй					
		82	14	5					
12	Илүү цагаар буюу 7 хоногийн амралтын өдөр ажиллаад нөхөж амраагүй бол 1.5 буюу түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс авч чадаж байна уу ?	A \тийм\	Б \үгүй\	Бөглөөгүй					
		1	97	4					
13	Нийтээр амрах ажлын өдөр	A \тийм\	Б \үгүй\	Бөглөөгүй					

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

	ажиллаад нөхөж амраагүй бол дундаж цаинг 2.0 дахин нэмэгдүүлсэн цалин хөлс авч чадаж байна уу ?						
		2	96	4			
14	Төрийн албаны тухай ШШГ тухай , цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай зэрэг хууль тогтоомжийн дагуу эдлэх давуу боломж, тусгай хөнгөлөлт нэмэгдэлийн талаар тодорхой мэдэх үү ?	А \тийм\	Г \үгүй\	Бөглөөгүй			
		63	34	5			
15	Дээр дурдсан давуу боломж, тусгай хөнгөлөлт , нэмэгдэлийн талаар мэдээлэл авах боломж нээлттэй юу?	А \тийм\	Г \үгүй\	Бөглөөгүй			
		63	30	9			
16	Ажил үүрэгтэй холбоотой дараах хүндрэл бэрхшээл гардаг уу ?				Байнга	Хааяа	Үгүй
		Хэт хүйтэн буюу халуун задгай талбайд хамгаалтгүй ажиллах			22	33	28
		Мэргэжлээс шалтгаалсан өвчин тусах			28	20	28
		Удирдлагийн зүгээс хэл амаар доромжлох			6	27	31
		Ялтнуудын зүгээс хэл амаар доромжлох			13	16	47
		Удирдах албан тушаалтан биед халдах			1	6	59
		Ялтан биед халдах				7	64
		Зодуулах					31
		Дарга нар хэл амаар доромжлох			1		
Хэвийн бус нөхцөлд ажиллах			3				
16.1	Хэт хүйтэн буюу халуунд задгай талбайд хамгаалалтгүй ажиллах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй		
		22	33	28	19		

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

16.2	Мэргэжлээс шалгаалсан өвчин тусах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй
		28	20	28	26
16.3	Удирдлагын зүгээс хэл амаар доромжлох	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй
		6	27	31	38
16.4	Ялтнуудын зүгээс хэл амаар доромжлох	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй
		13	16	47	26
16.5	Удирдах албан тушаалтан биед халдах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй
		1	6	59	36
16.6	Ялтан биед халдах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй
			7	64	31
16.7	Зодуулах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй
				31	
17	Дээр дурдсан нөхцөл байдлыг үр дүнтэй шийдвэрлэх албан ёсны тогтолцоо (тусгай ажилтан ажиллалуулах гомдол шийдвэрлэх эвлэрүүлэх гэх мэт)танай байгууллагад ажилладаг уу	А \тийм \	Б \үгүй\	Бөглөөгүй	Тийм бол тодорхой бичнэ үү ?
		24	67	11	-Ангийн удирдлага тухай бүрд нь зохих хуулийн дагуу шалгаж хариуг мэдэгддэг -Үр дүнтэй шийдвэрлэдэг, -ёс зүйн хороо ажилладаг, -гомдол өргөдөл зэргийг тодорхой албан тушаалтан хариуцаж шийдвэрлэдэг. -босоо удирдлагийн дагуу Удирдах албан тушаалтанд мэдэгдсэнээр асуудлыг шийдвэрлүүлдэг Дэглэм харуул хамгаалтын байцаагч төлөөлөгчөөр дамжуулан шийдвэрлүүлдэг Ангийн төлөөлөгч шийдвэрлэж өгдөг бид тэр хүнд л ханддаг
18	Дээр дурдсан хүндрэл	Бичнэ үү ?			

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

	бэрхшээл гарсан тохиолдолд хэнд ханддаг вэ?	Ангийн удирдлага - 7 Боловсон хүчин - 3 Албаны дарга - 3 Дээд удирдлага – 2 Тухайн асуудлыг шийдвэрлэх албан тушаалтан - 6 Хэнд ч ханддаггүй -64 Хариулаагүй -11			
18	Ажил хийж байхдаа бэртэл гэмтсэн халдвар өвчин туссан бол энэ тухайгаа бичнэ үү ?	Тодорхой бичнэ үү ?			
		Тийм – 20 Үгүй - 82	<ul style="list-style-type: none"> - Халдварт сүрьеэ өвчин - Цэргийн албан хаагчийн эрчүүдийн адил норматив хийлгэдэг үүнээс болоод нуруундаа бэртэл авсан - Лобараторын хиймийн хоронд хордсон үүнээс үүдээд элэг муудсан - Автомашины осолд орсон - Хөлөө гэмтээж байсан. Уушиг устсан - Амьсгалын замын халдварт өвчин - Байнгын стрест ордог үүнээс болоод бамбай булчирхай болон зүрхний өвчтэй болж байна. - Шатнаас унаж хөлний махаа тасалж байсан. - Хээрийн сургалтын үед хөлөө хугалаж байсан. - Мөөгөнцөр сүрьеэ тусах магадлал өндөр байдаг. - Захын мэдэрлийн өвчин нүүрний саажилтын өвчин тусаж эмчлүүлсэн ч үлдэц үлдсэн. - Албаны автомашин осолдож тархи хүзүүндээ хүнд гэмтэл авч 3 хавиргаа хугалсан - Харшилтай болсон - Ажлын тэмцээнд орж байгаад долоовор хуруугаа мулталж байсан. - Ялтны амьдрах байранд байрлаж ажилснаар тамхины утаанд хордох нүүрээр юм гарах толгой байнга өвдөх болсон 		
19	Та жирэмсний болон амаржисний амралт, нярай хүүхэд үрчлэн авсан чөлөө авч байсан уу ?	А \Тийм\	Б \үгүй\	Бөглөөгүй	
		37	49	16	
20	Та хуульд заасны дагуу	Авсан	Аваагүй	Бөглөөгүй	

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

	жирэмсний болон амаржисний 120 хоногийн амралт , нярай хүүхэд үрчлэн авсан бол хүүхдээ 60 хоногтой болтол чөлөө авсан уу?					
		22	15	65		
21	Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 3 хүртэх настай хүүхэдтэй эцэг эх , хүүхэд асрах , чөлөө авах боломж танай байгууллагад нээлттэй юу?	А \Ямар ч асуудалгүй\	Б \бага зэрэг асуудалтай\	В \бэрхшээлтэй\	Г \ямар ч боломжгүй\	Бөглөөгүй
		26	18	22	3	33
22	Хүүхэд төрүүлэх асрахтай холбоотой доорхи бэрхшээл үүсдэг үү ?					
22.1	Хуульд заасны дагуу богиносгосон цагаар ажиллуулахгүй байх	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		27	18	27	35	
22.2	Үндэслэлгүй буюу хэлбэр төдий үндэслэлээр цалин хөлс хасах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		18	12	28	42	
22.3	Ажлаас халах халахаар сүрдүүлэх	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		13	17	31	42	
22.4	Ямар нэг байдлаар дарамтлах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		12	15	32	42	
22.5	Гэр бүлийн харьцаа тааламжгүй болох	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		9	15	35	42	
23	Таны хамт ажиллагч хэн	А	Б	Бөглөөгүй		

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

	нэгнийг хүүхэд төрүүлсэн , асарсан буюу түүнтэй холбоотой шалтгаанаар хохироосон тохиолдол гарсан уу ?	\тийм\	\үгүй\			
		11	71	20		
24	Танай байгууллагад албан тушаал дэвшихэд нас хүйс харгалзах , эрэгтэй албан хаагчдад давуу боломж олгох тохиолдол байдаг уу?	А \тийм\	Б \заримдаа\	В \Батлах аргагүй боловч хандлага мэдрэгддэг\	Г \огт үгүй \	Бөглөөгүй
		31	32	15	18	6
25	Танай байгууллагад хүйс харгалзах , эрэгтэй албан хаагчдад давуу боломж олгох тохиолдол байдаг уу ?	А \тийм\	Б \заримдаа\	В \Батлах аргагүй боловч хандлага мэдрэгддэг\	Г \огт үгүй \	Бөглөөгүй
		38	18	22	19	6
26	Танай байгууллагад мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулах хүйс,харгалзах , эрэгтэй албан хаагчдад давуу боломж олгох тохиолдол байдаг уу ?	А \тийм\	Б \заримдаа\	В \Батлах аргагүй боловч хандлага мэдрэгддэг\	Г \огт үгүй \	Бөглөөгүй
		18	23	6	47	8
27	Танай байгууллагад орон байр олгох зэрэг нийгмийн халамж хамгаалалын боломж хэрэгжүлэхэд эрэгтэй албан хаагчдад давуу боломж олгох тохиолдол байдаг уу	А \тийм\	Б \заримдаа\	В \Батлах аргагүй боловч хандлага мэдрэгддэг\	Г \огт үгүй \	Бөглөөгүй
		19	12	24	37	10

Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

28	21-24-р асуултуудад дурдсан буюу эдгээртэй холбоотой асуудал гардаг бол энэ талаараа дэлгэрэнгүй бичнэ үү ?	<p>Дэлгэрэнгүй бичнэ үү ?</p> <p>Хариулаагүй -64</p> <ul style="list-style-type: none"> - Цэргийн цол албан тушаал ахих боломжоор муу танил талтай албан хаагчид илүү эрх эдэлдэг. - Дээд шатны албан тушаалтнуудад л байр олгодог - Цол албан тушаал харж өгдөг - Ахлах цолтой албан хаагчид байр авч байсан нь цөөхөн - Голдуу дарга нарт хуваарлагддаг, албан тушаал харж харицдаг - Олон жил ажилласан хүмүүст олгох магадлалтай залуу шинээр ажиллагсдад олгох магадлал маш бага - Танил тал байхад тушаал дэвшэхэд асуудал байхгүй - Эрэгтэй эмэгтэй гэж ялгагдгүй - Сургалт семинарт хүйс заадаг байр орон сууцтай болход ажилласан жил хардаг 				
29	Албан тушаал дэвших , цол нэмэх , сургалтанд хамруулах , зэрэг албан хаагчийн хүйсийг харгалзах талаар таны бодол	<p>Дэлгэрэнгүй бичнэ үү</p> <p>Хариулаагүй -66</p> <ul style="list-style-type: none"> - Бэлгийн дарамтанд орж байж л тушаал дэвшдэг - Адилхан ажиллаж байгаа учир ялгаварлах асуудал баймааргүй юм. - Цол нэмэх асуудлыг удирдах албан тушаалтан нүүр царай бие хаа зэргийг харан танил талтай хүн л нэмдэг. - Залуу албан хаагчдыг илүү харж үздэг. - Эмэгтэй хүн дээшээ гарж чадахгүй. - Тодорхой шаардлагатай албан тушаалд л хүйс харгалзахад татгалзах зүйлгүй. - Арийн хаалгагүй бол мөд дэвшихгүй - Эрэгтэй хүнийг ажилд сонгох нь илүү, бид адилхан л боловсрол чадвартай байдаг - Эмэгтэй албан хаагч илүү байна гэж дандаа дарамталдаг - Цол нэмэх бол эмэгтэй хүнд хэцүү санагддаг - Ихэнхдээ дарга нарын эхнэр тушаал дэвшиж цол авдаг 				
30	Хамт ажилладаг эрэгтэй ажилтнуудын зүгээс дараах байдлаар харьцах тохиолдол байдаг уу ?					
30.1	Бэлгийн харьцаатай холбоотой эвгүйрэх , ичээх үг хэлэх	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	



Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа

		7	21	64	10	
30.2	Бэлгийн сэдэлтэй санал хүсэлт тавих , уриалах , тулгах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		2	8	81	11	
30.3	Ширтэх , шалиг нүдээр харах , дохио зангаа үзүүлэх	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		5	15	71	11	
30.4	Өдсөн зураг хэвлэмэл хуудас, дүрс үзүүлэх,мессэж бичих	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		1	9	82	10	
30.5	Хүзүү хоолой , хөх өгзөгийг , шүргэх , илэх гэх мэтээр биед хүрэх	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		7	15	68	12	
30.6	Хүчирхийлэхийг завдах	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
		1	3	86	12	
30.7	Хүчирхийлэх, бэлгийн харьцаанд орох	байнга	Хааяа	Үгүй	Бөглөөгүй	
			1	90	11	